МЭДЭЭ · 2020 оны 2-р сарын 4

МЭДЭГДЭЛ



МЭДЭГДЭЛ

Иргэн Г.Буяндоржоос 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид хандан нэр бүхий прокуроруудтай холбоотой гомдол гаргаж байгаа тухай мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээгээр цацагдсан.

Улсын Ерөнхий Прокурорын газраас холбогдох асуудлыг мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагаар шалгуулахаар шийдвэрлээд байна.

Тус мэдээлэлд нэр дурьдагдсан П.Халиун нь 2015 онд прокурорын байгууллагаас чөлөөлөгдсөн болно.

Улсын Ерөнхий Прокурорын газраас прокурорын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн дүрэм журмыг нэг мөр хэрэгжүүлж ажиллахад анхаарч ажиллаж байгаа болохыг мэдэгдэж байна.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

2020 оны 2 дугаар сарын 04